



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/338/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261668 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 261668 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 261668 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/385

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,478,987,925.17	1,617,031,440.25
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	431,782,849.00	187,741,830.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	431,782,849.00	187,741,830.00
31210	Төгрөг	431,782,849.00	187,741,830.00
31211	Төрийн сангийн харилцах	431,782,849.00	187,741,830.00
33	АВЛАГА	330,207,590.18	203,368,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	24,297,590.18	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	305,910,000.00	203,368,000.00
34	УРЬДЧИЛГАА	82,409,467.20	109,623,155.00
34600	Урьдчилж гарсан зардал	82,409,467.20	109,623,155.00
35	БАРАА МАТЕРИАЛ	634,588,018.79	1,116,298,455.25
35400	Хангамжийн материал	629,823,155.39	1,110,455,591.85
35410	Бичиг хэргийн материал	30,457,205.00	30,002,920.00
35420	Аж ахуйн материал	577,563,150.39	564,053,227.85
35430	Сэлбэг хэрэгсэл	15,911,800.00	30,371,100.00
35440	Түлш, шатах тослох материал	5,891,000.00	3,069,868.00
35470	Бусад хангамжийн материал	-	482,958,476.00
35500	Биологийн хөрөнгө	4,764,863.40	5,842,863.40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,900,128,363.69	13,892,508,746.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,900,128,363.69	13,892,508,746.42
39200	Биет хөрөнгө	14,052,694,473.69	13,477,092,076.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,856,873,188.00	11,856,873,188.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(195,284,629.44)	(392,899,182.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	830,570,498.16	830,570,498.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	(144,015,533.21)	(254,846,471.93)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,206,637,320.28	1,130,508,862.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(377,563,853.04)	(482,930,738.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	936,050,472.38	927,482,172.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(150,129,793.82)	(225,326,348.73)
39214	Бусад үндсэн хөрөнгө	93,153,568.02	91,582,768.02
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,596,763.64)	(3,922,670.80)
39300	Биет бус хөрөнгө	847,433,890.00	415,416,669.98
39301	Програм хангамж	192,663,000.00	191,201,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(17,073,750.00)	(47,127,250.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	671,844,640.00	271,342,420.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,379,116,288.86	15,509,540,186.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	352,964,170.00	140,301,401.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	352,964,170.00	140,301,401.00
41300	Өглөг	-	7,765,000.00
41360	Бусад өглөг	-	7,765,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,765,000.00
41400	Урьдчилж орсон орлого	352,964,170.00	132,536,401.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	352,964,170.00	132,536,401.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,026,152,118.86	15,369,238,785.67
51	Засгийн газрын хувь оролцоо	16,026,152,118.86	15,369,238,785.67
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	535,355,550.53	535,355,550.53
51200	Хуримтлагдсан үр дүн	14,914,491,486.31	14,761,553,513.12
51210	Өмнөх үеийн үр дүн	16,858,265,067.46	15,418,466,846.31
51220	Тайлант үеийн үр дүн	(1,943,773,581.15)	(656,913,333.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	576,305,082.02	72,329,722.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,379,116,288.86	15,509,540,186.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	20,551,410,268.98	12,576,957,664.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	880,119,085.24	70,938,596.50
120	Нийтлэг татварын бус орлого	880,119,085.24	70,938,596.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,954,140.00	70,899,446.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	385,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	100,954,140.00	70,514,446.50
120009	Бусад орлого	52,172,238.00	39,150.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	329,343,653.84	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	397,649,053.40	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,671,291,183.74	12,506,019,067.73
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,311,663,672.00	7,348,362,732.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,247,189,672.00	4,858,899,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,064,474,000.00	2,489,463,632.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,359,627,511.74	5,157,656,335.73
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	568,580,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,770,995,811.74	5,007,421,766.53
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	51,700.00	130,234,569.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,156,008,962.80	9,971,950,035.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,156,008,962.80	9,971,950,035.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,823,007,720.26	9,346,500,808.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,210,833,327.46	2,498,803,559.38
210101	Үндсэн цалин	1,505,827,578.83	1,721,502,890.18
210102	Нэмэгдэл	573,057,204.32	578,834,669.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	125,801,344.31	198,466,000.00
210104	Урамшуулал	1,027,200.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	5,120,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	260,441,536.04	290,650,775.59
210201	Тэтгэврийн даатгал	155,069,502.61	204,285,173.64
210202	Тэтгэмжийн даатгал	26,385,182.61	21,248,458.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,031,265.97	16,775,573.61
210204	Ажилгүйдлийн даатгал	5,230,558.54	4,033,929.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,725,026.31	44,307,640.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,994,185.10	96,886,738.16
210301	Гэрэл, цахилгаан	59,226,032.80	53,139,358.83
210302	Түлш, халаалт	44,358,044.76	37,520,535.33
210303	Цэвэр, бохир ус	4,410,107.54	6,226,844.00
2104	Хангамж, бараа материалын зардал	255,126,210.02	359,046,274.75
210401	Бичиг хэрэг	50,420,175.00	68,539,132.00
210402	Тээвэр, шатахуун	25,821,300.00	27,692,558.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	47,492,379.33	50,134,054.21
210404	Ном, хэвлэл	1,740,740.00	1,416,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,200,000.00	6,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	123,451,615.69	189,846,101.54
210408	Бараа материал акталсны зардал	-	15,417,629.00

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,784,805.00	49,350,797.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,109,805.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	31,514,440.00
210604	Урсгал засвар	1,675,000.00	17,836,357.00
2107	Томилолт, зочны зардал	9,336,450.00	60,047,036.00
210701	Гадаад албан томилолт	50,000.00	14,561,094.00
210702	Дотоод албан томилолт	9,286,450.00	19,098,380.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	26,387,562.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	745,895,410.90	246,065,009.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	682,505,910.10	235,456,528.80
210803	Даатгалын үйлчилгээ	5,601,484.80	4,825,467.24
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,020,400.00	535,762.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50,702,450.00	5,097,000.00
210807	Газрын төлбөр	6,065,166.00	150,251.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,182,595,795.74	5,745,650,618.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,565,182,611.74	5,021,072,966.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,469,473.25	53,058,570.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	594,943,710.75	671,519,081.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,333,001,242.54	625,449,227.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	53,819,265.55	51,665,373.33
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	53,819,265.55	51,665,373.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	628,101,169.00	524,920,266.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,960,000.00	377,480,266.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	116,640,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,170,050.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	610,971,119.00	30,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	651,080,807.99	48,863,587.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	651,029,107.99	48,349,287.87
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	51,700.00	514,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,395,401,306.18	2,605,007,628.97
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,339,174,887.33	3,261,920,962.16
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,121,297,963.91	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	448,261,960.42	609,480,530.16
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,369,614,963.00	33,476,800.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	2,400,000,000.00	2,618,963,632.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,943,773,581.15)	(656,913,333.19)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,355,550.53	2,272,876,263.39	15,161,693,886.09	17,969,925,700.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,696,571,181.37	1,696,571,181.37
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,355,550.53	2,272,876,263.39	16,858,265,067.46	19,666,496,881.38
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,696,571,181.37)	-	(1,696,571,181.37)
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,943,773,581.15)	(1,943,773,581.15)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,355,550.53	576,305,082.02	14,914,491,486.31	16,026,152,118.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	503,975,360.00	503,975,360.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,355,550.53	576,305,082.02	15,418,466,846.31	16,530,127,478.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(503,975,360.00)	-	(503,975,360.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	(656,913,333.19)	(656,913,333.19)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	535,355,550.53	72,329,722.02	14,761,553,513.12	15,369,238,785.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	19,994,132,194.00	12,860,853,927.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	321,514,822.00	36,440,354.00
120	Нийтлэг татварын бус орлого	321,514,822.00	36,440,354.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	385,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	385,000.00
120009	Бусад орлого	321,514,822.00	36,055,354.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	19,672,617,372.00	12,824,413,573.58
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,311,663,672.00	7,348,362,732.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,247,189,672.00	4,858,899,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,064,474,000.00	2,489,463,632.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,360,953,700.00	5,476,050,841.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	568,580,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,772,322,000.00	5,019,906,272.38
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	51,700.00	436,144,569.20

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,221,602,454.00	8,222,446,016.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,221,602,454.00	8,222,446,016.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,581,365,023.20	7,388,909,283.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,235,130,917.64	2,474,505,969.20
210101	Үндсэн цалин	1,530,089,890.78	1,697,205,300.00
210102	Нэмэгдэл	573,092,482.55	578,834,669.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	125,801,344.31	198,466,000.00
210104	Урамшуулал	1,027,200.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	5,120,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	260,441,536.04	290,650,775.59
210201	Тэтгэврийн даатгал	155,069,502.61	202,459,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	26,385,182.61	23,074,432.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,031,265.97	16,775,573.61
210204	Ажилгүйдлийн даатгал	5,230,558.54	4,033,929.00
210205	Эрүүл мэндийн даатгал	52,725,026.31	44,307,640.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,713,652.30	85,167,270.96
210301	Гэрэл, цахилгаан	70,945,500.00	41,419,891.63
210302	Түлш, халаалт	44,358,044.76	37,520,535.33
210303	Цэвэр, бохир ус	4,410,107.54	6,226,844.00
2104	Хангамж, бараа материалын зардал	271,115,647.33	269,175,116.21
210401	Бичиг хэрэг	70,496,540.00	61,315,753.00
210402	Тээвэр, шатахуун	22,357,700.00	23,620,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	47,492,379.33	50,134,054.21
210404	Ном, хэвлэл	1,740,740.00	1,416,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,200,000.00	6,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	122,828,288.00	126,688,309.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,321,260.00	118,383,657.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	74,055,260.00	53,325,460.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,071,000.00	40,658,040.00
210604	Урсгал засвар	7,195,000.00	24,400,157.00
2107	Томилолт, зочны зардал	9,336,450.00	72,555,841.00
210701	Гадаад албан томилолт	50,000.00	14,728,084.00
210702	Дотоод албан томилолт	9,286,450.00	20,349,606.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	37,478,151.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,281,777,110.90	814,388,394.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	795,606,310.10	376,274,438.80
210803	Даатгалын үйлчилгээ	5,601,484.80	4,825,467.24
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,020,400.00	535,762.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,483,750.00	431,791,320.00
210807	Газрын төлбөр	6,065,166.00	961,406.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,321,528,448.99	3,264,082,259.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,285,804,175.74	3,221,525,389.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,724,273.25	42,556,870.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,640,237,430.80	833,536,733.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	53,819,265.55	51,665,373.33
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	53,819,265.55	51,665,373.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	628,101,169.00	517,155,266.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,960,000.00	369,715,266.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	116,640,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,170,050.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	610,971,119.00	30,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	958,316,996.25	264,716,093.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	651,029,107.99	48,349,287.87
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	307,287,888.26	216,366,805.85

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,772,529,740.00	4,638,407,911.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,549,976,041.50	2,821,829,180.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,549,976,041.50	2,821,829,180.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,549,976,041.50	2,821,829,180.00
220001	Барилга байгууламж	664,474,000.00	-
221001	Их засвар	-	1,675,752,242.00
222001	Тоног төхөөрөмж	2,400,000,000.00	943,211,390.00
223001	Бусад хөрөнгө	91,833,923.50	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	393,668,118.00	202,865,548.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,549,976,041.50)	(2,821,829,180.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	222,553,698.50	1,816,578,731.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	209,229,150.50	431,782,849.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	431,782,849.00	187,741,830.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,378,294,800.00	7,300,398,444.13	4,077,896,355.87	64.2
УРСГАЛ ЗАРДАЛ	4,878,294,800.00	4,810,934,812.13	67,359,987.87	98.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,320,442,600.00	4,272,914,172.80	47,528,427.20	98.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,474,285,700.00	2,474,285,700.00	-	100.0
Үндсэн цалин	1,697,205,300.00	1,697,205,300.00	-	100.0
Нэмэгдэл	578,614,400.00	578,614,400.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	198,466,000.00	198,466,000.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307,494,700.00	290,650,775.59	16,843,924.41	94.5
Тэтгэврийн даатгал	202,459,200.00	202,459,200.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	26,258,900.00	23,074,432.05	3,184,467.95	87.9
ҮОМШӨ-ний даатгал	21,007,100.00	16,775,573.61	4,231,526.39	79.9
Ажилгүйдлийн даатгал	5,251,700.00	4,033,929.00	1,217,771.00	76.8
Эрүүл мэндийн даатгал	52,517,800.00	44,307,640.93	8,210,159.07	84.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,673,400.00	85,167,270.96	1,506,129.04	98.3
Гэрэл, цахилгаан	41,586,100.00	41,419,891.63	166,208.37	99.6
Түлш, халаалт	38,002,600.00	37,520,535.33	482,064.67	98.7
Цэвэр, бохир ус	7,084,700.00	6,226,844.00	857,856.00	87.9
Хангамж, бараа материалын зардал	274,902,200.00	269,175,116.21	5,727,083.79	97.9
Бичиг хэрэг	61,446,600.00	61,315,753.00	130,847.00	99.8
Тээвэр, шатахуун	23,620,200.00	23,620,200.00	-	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54,910,400.00	50,134,054.21	4,776,345.79	91.3
Ном, хэвлэл	1,965,800.00	1,416,800.00	549,000.00	72.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,270,500.00	6,000,000.00	270,500.00	95.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	126,688,700.00	126,688,309.00	391.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	142,208,700.00	141,776,065.00	432,635.00	99.7
Багаж, техник, хэрэгсэл	76,793,800.00	76,717,868.00	75,932.00	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	40,783,300.00	40,658,040.00	125,260.00	99.7
Урсгал засвар	24,631,600.00	24,400,157.00	231,443.00	99.1
Томилолт, зочны зардал	76,584,000.00	72,555,841.00	4,028,159.00	94.7
Гадаад албан томилолт	16,713,200.00	14,728,084.00	1,985,116.00	88.1
Дотоод албан томилолт	21,345,800.00	20,349,606.00	996,194.00	95.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	38,525,000.00	37,478,151.00	1,046,849.00	97.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	909,786,000.00	891,319,534.04	18,466,465.96	98.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	469,042,300.00	453,205,578.80	15,836,721.20	96.6
Даатгалын үйлчилгээ	4,825,500.00	4,825,467.24	32.76	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	1,554,400.00	535,762.00	1,018,638.00	34.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,402,400.00	431,791,320.00	611,080.00	99.9
Газрын төлбөр	1,961,400.00	961,406.00	999,994.00	49.0
Бараа үйлчилгээний бусад зардал	48,507,900.00	47,983,870.00	524,030.00	98.9
Бараа үйлчилгээний бусад зардал	5,556,000.00	5,427,000.00	129,000.00	97.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,951,900.00	42,556,870.00	395,030.00	99.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	557,852,200.00	538,020,639.33	19,831,560.67	96.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	52,858,400.00	51,665,373.33	1,193,026.67	97.7
Засгийн газрын гадаад шилжүүлэг	52,858,400.00	51,665,373.33	1,193,026.67	97.7
Бусад урсгал шилжүүлэг	504,993,800.00	486,355,266.00	18,638,534.00	96.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	388,353,800.00	369,715,266.00	18,638,534.00	95.2
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	116,640,000.00	116,640,000.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,500,000,000.00	2,489,463,632.00	4,010,536,368.00	38.3
Их засвар	1,800,000,000.00	1,675,752,242.00	124,247,758.00	93.1
Тоног төхөөрөмж	4,700,000,000.00	813,711,390.00	3,886,288,610.00	17.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,378,294,800.00	7,300,398,444.13	4,077,896,355.87	64.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,378,294,800.00	7,300,013,444.13	4,078,281,355.87	64.2

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Улсын төсвөөс санхүүжих	11,378,294,800.00	7,300,013,444.13	4,078,281,355.87	64.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	385,000.00	- 385,000.00	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	385,000.00	- 385,000.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	217.00	217.00	-	100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	
АЖИЛЛАГСАДЫН ТОО	108.00	108.00	-	100.0
Удирдах ажилтан	10.00	10.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	90.00	90.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	5,476,050,841.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	5,346,550,841.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	5,122,668,541.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	220,269.20
210102	Нэмэгдэл	-	220,269.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	102,542,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	102,542,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,019,906,272.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,019,906,272.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	223,882,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	20,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	20,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	203,882,300.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	203,882,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	129,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	129,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	129,500,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	5,476,050,841.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	5,476,050,841.58
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	305,910,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,149,906,272.38
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	20,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	234,569.20

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын аудитор Ж.Нямцэцэг, ахлах аудитор Б.Энхжин нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/445 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хууль зүй, дотоод хэргийн яамны зорилгыг “Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэх, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Хууль зүйн нэгдсэн бодлогын удирдамж, хууль сахиулах стратеги, бодлого төлөвлөлтийг оновчтой тодорхойлох;
- Бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх;
- Хууль тогтоомжийн системчлэл, захиргааны байгууллагын шийдвэрийг хянах, бүртгэх, нэгдсэн сан хөтлөх;
- Хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалт, сурталчилгаа, төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн тусалцаа, үйлчилгээ үзүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 13,522,156.1 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 270,443.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 869,576.1 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	431,782.8	187,741.8	(244,041.0)
Авлага	330,207.6	203,368.0	(126,839.6)
Урьдчилгаа	82,409.5	109,623.2	27,213.7
Бараа материал	634,588.0	1,116,298.5	481,710.4
Үндсэн хөрөнгө	14,900,128.4	13,892,508.7	(1,007,619.6)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,379,116.3	15,509,540.2	(869,576.1)
Богино хугацаат өр төлбөр	352,964.2	140,301.4	(212,662.8)
Засгийн газрын хувь оролцоо	16,026,152.1	15,369,238.8	(656,913.3)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,379,116.3	15,509,540.2	(869,576.1)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 187,741.8 мянган төгрөг болж өмнөх оноос 244,041.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаас барьцаа хөрөнгө байршуулсан хөрөнгийг чөлөөлсөн нь голлон нөлөөлжээ. Тайлант оны эцэст ахмадын сангийн мөнгөн хөрөнгө 55,205.4 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгө 132,536.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Авлага дансны үлдэгдэл 203,368.0 мянган болж, өмнөх оноос 126,839.6 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн 203,368.0 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлж, санхүүжилтийн авлага үүсгэснээс шалтгаалжээ.

Бараа материалын данс 1,116,298.5 мянган төгрөг болж, 481,710.4 мянган төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагуудад бараа материалыг тайлант онд хуваарилж, шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс 13,892,508.7 мянган төгрөг болж, 1,007,619.6 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 211 дүгээр тогтоолоор дотоод 579,975.4 мянган төгрөгийн үнэ бүхий газрыг балансаас баланст шилжүүлсэн болон тайлант оны 671,519.1 мянган төгрөгийн элэгдэл, хорогдлын дүн нөлөөлжээ.

Өр төлбөрийн данс 140,301.4 мянган төгрөг болж, 212,662.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд байршуулсантай барьцаа хөрөнгийг чөлөөлсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,369,238.8 мянган төгрөг болж 656,913.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Тайлант онд санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 7,962,083.6 мянган төгрөгөөр буюу 38.7 хувиар буурсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,388,290.5 мянга, хөрөнгийн санхүүжилт 575,010.4 мянга, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 4,621,205.0 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Үндсэн үйл ажиллагааны зардал өмнөх оноос 6,171,689.9 мянган төгрөгөөр буюу 38.2 хувиар буурсан нь бараа, үйлчилгээний зардал 5,464,138.0 мянга, урсгал шилжүүлэг 707,552.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төсвийн шууд захирагчийн 2021 оны төсвийн төсөлд 11,003,647.3 мянган төгрөгөөр, үүнээс бараа үйлчилгээний зардлын төсвийг 10,943,384.8 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 60,262.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 374,647.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 11,378,294.8 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 11,378,294.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4,878,294.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 6,500,000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,300,013.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 4,810,934.8 мянган төгрөг, хөрөнгийн оруулалтад 2,489,463.6 мянган төгрөг зарцуулж 48,349.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,300,398.4 мянган төгрөг буюу 4,077,896.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, төсвийн гүйцэтгэл 64.2 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 16,843.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 18,466.4 мянга, урсгал шилжүүлгийг 19,831.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, хөрөнгийн зардлыг харьяа байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн салбарын их засвар, тохижилтод 1,800,000.0 мянга, Хууль зүй, дотоод хэргийн салбарын программ хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд 4,700,000.0 мянган, нийт 6,500,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв батлагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70712	Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт	4,878,294.8	4,858,899.1	19,395.7	99.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,649,266.0	3,649,266.0	-	100.0
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	3,595.7	3,595.7	-	100.0
1.3	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	52,858.4	52,858.4	-	100.0
1.4	80704	Алдар цолтой ахмад настанд олгох тэтгэмж	116,640.0	116,640.0	-	100.0
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	388,353.8	383,553.8	4,800.0	98.8
1.6	81557	Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөр	25,000.0	14,000.0	11,000.0	56.0
1.7	81558	Нэг иргэн-нэг бүртгэл" хөтөлбөр"	426,000.0	426,000.0	-	100.0
1.8	81559	Хууль тогтоомжийг боловсруулах	216,580.9	216,580.9	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хууль зүй, дотоод хэргийн яамны нэмэлт санхүүжилтийн дансанд 5,476,050.8 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна. Үүнд:

- Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс авсан санхүүжилтийн 2020 оны зарцуулаагүй үлдэгдэл 305,910.0 мянган төгрөг;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны ажлын гүйцэтгэлийг үнэлж 20,000.0 мянган төгрөг;
- Засгийн газрын нөөц сангаас 5,149,906.3 мянган төгрөг;
- Бусад орлого 234.5 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлын онцолсон хэсэг

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар нийгмийн халамжийн сангаас олгож байсан Алдар цолтой ахмад настанд төрөөс олгох тэтгэмжийг харьяа төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт тусгаснаар тайлант онд нийт 116,640.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чадавхыг сайжруулах" төслийн хүрээнд "Хууль зүй, дотоод хэргийн салбарын санхүүгийн нэгдсэн удирдлагын программ"-ын шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус яамны ХШҮДА газар нь Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 26 зорилтын хүрээнд 234 арга хэмжээ төлөвлөж ажилласнаас 96.6 хувийн хэрэгжилттэй байгаа нь шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа хэрэгжилт үр дүнг нь нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 9 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь шилэн дансны цахим хуудсанд 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчид 681,284.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 158,864.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 85.5 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолын хэрэгжилтийг дараагийн аудитаар үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 300,610.1 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 288,285.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 12,325.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд шинээр нэвтрүүлсэн 179,473.1 мянган төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг биет бус хөрөнгөд бүртгээгүй, зардалд шууд тусгасан, удирдлагын мэдээллийн систем хөгжүүлэх ажлын 102,542.0 мянга, олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл хэвлүүлэх 6,270.0 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тус тус урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй алдааг залруулж, баталгаажуулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн орон нутаг дахь салбар нэгжид хүлээлгэн өгсөн 12,325.0 мянган төгрөгийн 5 ширхэг компьютерыг данс бүртгэлээс хасаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандаж, холбогдох журмын дагуу ашиглагч байгууллагад шилжүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр, аудитын код	Алдаа, зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
						Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар													
1		Тайлант онд шинээр нэвтрүүлсэн 179,473.1 мянган төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг биет бус хөрөнгөд бүртгээгүйгээр зардалд тусгасан	Залруулах	1	179,473.1	1	179,473.1						
2	Хууль зүй, дотоод хэргийн яам АХГ-2022/338/НА-СТА-ТШЗ	Удирдлагын мэдээллийн систем хөгжүүлэх ажлын төлбөрт төлсөн 102,542.0 мянга, олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл хэвлүүлэх 6,270.0 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тус тус урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй	Залруулах	1	108,812.0	1	108,812.0						
3		Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн орон нутаг дахь салбар нэгжид хүлээлгэн өгсөн 12,325.0 мянган төгрөгийн 5 ширхэг компьютерыг хүлээн авсан байгууллагуудын данс бүртгэлд шилжүүлэн өгөөгүй байна.	Зөвлөмж	1	12,325.0							1	12,325.0
Дүн				3	300,610.1	2	288,285.1					1	12,325.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал													
1	Хууль зүй, дотоод хэргийн яам АХГ-2022/338/НА-СТА-ТШЗ	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.	1								1	-
Дүн				1								1	-
Нийт дүн				4	300,610.1	2	288,285.1					1	-
												1	12,325.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 134/А0160062
АХГ-2022/338/НА-СТА-ТУС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу гүйцэтгэсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Хосбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭНХЖИН

АУДИТОР

Ж.НЯМЦЭЦЭГ

9006109
9019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-142.Docx

0010800454

